

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 10 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 220

Улаанбаатар хот

Г Арилжааны цагийг сунгах тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2 дах заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 258 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжааг ажлын өдрүүдэд 11:00-13:00 цагийн хооронд байхаар тус тус шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.
2. Монголын хөрөнгийн биржийн тухайн өдрийн арилжааны файлыг арилжаа дууссанаас хойш аливаа засвар, өөрчлөлтгүйгээр “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д шууд шилжүүлж байхыг Монголын хөрөнгийн бирж-д үүрэг болгосугай.
3. Техникийн шинжтэй алдаа гарсан тохиолдолд Монголын хөрөнгийн бирж болон “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК даруй Хороонд мэдэгдэж, улсын байцаагчийн хяналтан дор холбогдох алдааг тухай бүр залруулж байхыг Монголын хөрөнгийн бирж ХК /Р.Содхүү/-д, “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д, тухайн өдрийн арилжааны файлыг шилжүүлэхдээ техникийн алдаа байгаа эсэх талаарх тодорхойлолтыг Монголын хөрөнгийн бирж ХК /Р.Содхүү/-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолд нийцүүлэн холбогдох дүрэм, журамдаа зохих өөрчлөлтийг оруулж 2009 оны 12 дугаар сард багтаан тус Хороонд эргэж мэдэгдэхийг Монголын хөрөнгийн бирж /Р.Содхүү/-д, “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус даалгасугай.
5. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн, арилжааны цагийг сунгасан тухай мэдээллийг олон нийтэд мэдээлж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д үүрэг болгосугай.

6. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ёнэт цаасны газар /Э.Ганбат,
олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Х.БУМ-ЭРДЭНЭ



МОНГОЛ
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

___ оны __ сарын __ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

Г

Г

ААЭГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ